



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 04 сарын 18

Мерси Кор Монгол ОУБ –ын хэрэгжүүлж буй “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөр нь мал аж ахуйн үйлдвэрлэл, экспортыг дэмжиж, иргэд, төрийн байгууллагуудын хямрал, саад бэрхшээлийг даван туулах чадавхийг бэхжүүлэх замаар хот, хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж, нийгмийн сайн сайхан байдал, тогтвортой хөгжлийг хангахыг зорьсон 4 жилийн хөтөлбөр бөгөөд нийт 8 аймагт хэрэгжинэ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 7 аймагт малын тэжээлийн ургамал тариалах үйл ажиллагаанд төслийн зүгээс дэмжлэг үзүүлэх болсон бөгөөд хамтран ажиллах үр тариа, тэжээлийн таримлын үр нийлүүлэгч төрөлжсөн ААН-үүдийг битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерээр худалдан авах үр:

- Эрдэнэшиш (Симкен -11) – 300 кг
- Наранцэцэг (Инсей) – 240 кг
- Цагаан арвай (Шимт, Бурхант -1)– 5940 кг
- Улаан буудай (Дархан -144) – 5600 кг
- Овьёос (Ровесник; Алтанбороо) – 24650 кг
- Царгас (Бургалтай)– 1890 кг

Бүрдүүлэх бичиг баримт:

1. Үр тариа, тэжээлийн таримлын аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалтанд оролцох тухайгаа илэрхийлсэн үнийн санал бүхий хүсэлт
2. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар
3. Аж ахуйн нэгжийн танилцуулга /эзэмшиж буй талбайн хэмжээ, хөрс, цаг уурын онцлог, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт, хураан авсан ургацын хэмжээ сүүлийн 5 жилээр, санхүүгийн байдал, мэргэжилтэй боловсон хүчний танилцуулга, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллаж байсан туршлага, га-гаас авсан ургацын хэмжээ зэргийг тусгана./
4. Үр тариа, тэжээлийн ургамлын үрийг хадгалах стандарт шаардлага хангасан агуулахтай байх
5. Үрийн чанарыг тодорхойлсон албан ёсны баталгаажсан бичиг
6. Энэ чиглэлээр гүйцэтгэсэн ажлын туршлага
7. Сүүлийн 10-аас доошгүй жилийн хугацаанд үр тариа, тэжээлийн таримлын үйлдвэрлэлээр тогтвортой амжилт гаргасан, дунд болон оройн болцтой сортын үр бүрэн боловсрохуйц дулааны хангамжтай бүс нутагт тариалан эрхэлдэг байх
8. Монгол орны нөхцөлд зохицсон нутагшсан болон тарималжсан сортуудын үр үржүүлэх эрх, баримтаар баталгаажсан байх
9. Сумын газрын албаны тодорхойлолт

Тендерт оролцогч нь дээрх бичиг баримтуудыг 2017 оны 04 сарын 24-ны өдрийн 12:00 цагаас өмнө доор заасан хаягаар ирүүлнэ үү. Үүнд:

Хүлээн авах хаяг: Мерси Кор Монгол ОУБ, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, АОС -30-1

Утас: 461145 Факс: 461048